



ЖИНСТ УВС ХК

*ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН*

ЖИЛИЙН ТАЙЛАН

2018

Хүчтэй. Хамтдаа.

АГУУЛГА

ТУЗ-ийн даргын мэндчилгээ	4
Алсын хараа, Эрхэм зорилго	9
2018 оны эдийн засгийн орчин	10
Компанийн тухай	12
Хувьцаа эзэмшигчид	13
Төлөөлөн Удирдах Зөвлөл	14
2018 оны үйл ажиллагааны тайлан	16
Хөрөнгө оруулалтын багц	18
Хувьцааны ханшийн өөрчлөлтийн мэдээ	19
2018 оны санхүүгийн аудитын тайлан	20

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Хүндэт хувьцаа эзэмшигч та сайхан хаваржиж байна уу?

Улиран одсон 2018 онд бид олон жил бэлтгэсэн ажлын үр дүнг тооцож, огцом өсөлтийг хангах сууриа эцэслэн тавьсан жил боллоо. Юуны түрүүнд бидэнд итгэж, бидэнтэй хамт байсан танд гүн талархал илэрхийлж, танд болон танай гэр бүл, хамт олонд хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе! Бидний та бүгдэд байнга сануулж ирсэн нэг зүйл бол хөрөнгө оруулалт хийнэ гэдэг нь асар их итгэл болон хариуцлагын асуудал мөн. Компанийн хувьцааг авна гэдэг нь тухайн компанийн

үйл ажиллагаа, удирдлага, бүтээгдэхүүн, үзэл санаанд итгэх, түүнийг дэмжих дээд хэлбэр гэж би хардаг. Тэрхүү итгэлийн нэг хэмжүүр нь компанийн хувьцааны эрэлт, түүнийг дагасан үнэ өөрөө байдаг. Богино хугацаанд ашиг хонжоо хийх зорилгоор хөрөнгө оруулалт хийхээс аль болох зайлсхийх хэрэгтэй гэдгийг би ямагт сануулж ирсэн. Алдаа хийж, алдагдалд орох магадлал тун өндөр учраас. Тийм ч учраас бид урт хугацаанд үнэ цэнийг бий болгох хөрөнгө оруулалтыг эрэлхийлэн хийж, бүхий л анхаарлаа зөвхөн түүнд төвлөрүүлэн ажилладаг билээ. Та бүхэн ч биднээс тийм л зүйлийг хүлээгээсэй гэж

би хүсдэг. Жинст Увс (JIV) буюу Хөрөнгө Оруулагч Үндэстний хувьцааны 2018 оны хаалтын ханш 2,341 төгрөгт хүрэв. 2016 онд бид мянгуулаа цугларч, хөрөнгөө нийлүүлж, Хөрөнгө Оруулагч Үндэстэн гэх хөдөлгөөнийг эхлүүлж байсан бол бидний анхны хөрөнгө оруулалт 130 хувиар өссөн байна. Энэ бол чамгүй сайн үзүүлэлт гэж би бодож байна. Та ч санал нийлэх байх. Бидэнд итгэж, бидний үйл хэргийг дэмжиж, ямагт тэвчээр заан хамт байсан та бүхэндээ би талархаж, мэхийн ёслоё!

Энэхүү тайланг бичиж буй энэ үед Жинст Увс (JIV) нь Ард Санхүүгийн Нэгдэлтэй нийлэх хүсэлтээ зохицуулагч байгууллагад гаргаж, Монголын Хөрөнгийн Биржээс энэхүү нэгдэх процессыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос манай саналыг судлан хянаж, шийдвэрээ хараахан гараагүй байна.

МХБ дээр арилжаалагдаж байгаа манай JIV болон MNP хувьцаа тогтвортой үнэлгээтэй явж ирсэн бол Ард Санхүүгийн Нэгдэл маань өөрөө JIV-тэй нэгдэх байдлаар олон нийтэд нээлттэйгээр хувьцаагаа арилжаалах

боломж нээгдэхийг бид тэсэн ядан хүлээж байна.

Бид trade.mn гэх Монголын анхдагч криптовалютын биржид хөрөнгө оруулж, таны цахим түрийвчтэй холбож өгснөөр та өөрийн крипто хөрөнгө оруулалтыг хэзээд ч, хаанаас ч удирдах боломжтой боллоо. Тиймээ, бид Биткойн болон бусад алткойн, блокчэйн технологид тодорхой хэмжээний хөрөнгө оруулж ирснээ үргэлжлүүлэх болно. Бид Монголд анхлан КриптоҮндэстэн Чуулганыг зохион байгуулж, блокчэйн хувьсгалд улс орон, ард түмнээ уриалсан билээ. 2018 оны эхээр бид КриптоҮндэстэн ХХК-г 150 хөрөнгө оруулагчидтай хамтран байгуулснаар энэ чиглэлд мөс хагалсан юм. Хоосон газар хувьцааны үнэ өсөхгүй, итгэл бий болохгүй - бид хэлснээ хийсээр ирснийг та бүхэн харсан.

Бид амалсан ёсоороо Ард Даатгалын IPO-г хийж, компанийнхаа 30 хувийг 5.3 тэрбум төгрөгөөр олон нийтэд санал болгосон. Үүний үр дүнд Ард Даатгал хамгийн олон хүний өмчийн даатгалын компани болж чадсан. Мэргэжлийн байгууллагуудын хийсэн үнэлгээ 1,200 гаруй төгрөгөөр тогтсон бөгөөд AIC

2018 оныг 770 төгрөгөөр хаагдсан нь цаашид энд өсөх боломж агуулагдсаар байгааг илтгэнэ. Ард Даатгал үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөж, 2018 онд хамгийн өндөр хураамжийн орлого, хөрөнгө оруулалтын орлого бүрэлдүүлж чадсан юм. 2019 онд Ард Даатгал үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ой тохиож байна. Бид энэ ойгоо ажил хөдөлмөрийн өндөр амжилтаар угтаж, та бүгдтэйгээ хамт тэмдэглэхээр зэхэж байна. Бид даатгалын үйлчилгээг танд цахимаар ойртуулж, хүртээмжийг улам нэмэгдүүлж, зах зээлд ашиг орлогоороо манлайлах зорилго дэвшүүлж байгаа. Та дэмжээрэй!

Бид оны дундуур Монгол Шуудангийн 3.5 хувийг худалдсан боловч компанийн хувьцааны үнэ 684.03 төгрөгт хүрч хаагдсан нь манай үнэлгээнд 2.3 тэрбумын эерэг нөлөө үзүүлээ. Цахим худалдаа Монголд газар авч, бараа, бүтээгдэхүүний хүргэлтийн үйлчилгээний орлого огцом өсөн банк санхүүгийн үйлчилгээг шуудангийн салбараар явуулснаар орлогын шинэ нэр төрөл орж ирнэ гэж бид тооцоолж байгаа. Төрийн үйлчилгээг цахимаар хүргэх ажилд Монгол Шуудан хүчин зүтгэхээр болж, улсаас тодорхой хэмжээний төсөв

мөнгө батлагдсан нь Монгол Шуудангийн шинэчлэлийн ажилд түлхэц болно гэж бид харж байгаа. 2019 онд төрийн үлдсэн хувийн хувьчлал Монголын Хөрөнгийн Биржээр үргэлжлэн явагдаж, та бид хамтдаа Монгол Шуудангийн илүү их хувийг хамтдаа эзэмших боломж нээгдэнэ гэдэгт би итгэлтэй байна. Ард Кредит бол манай цахим банкны стратегийн цөм болсоор явж ирсэн. 2018 онд бид цахим банкаа босгож чадсан - яг нэг жилийн өмнө Грэйп Сити болон Мост Монитой стратегийн түншлэлийн гэрээ байгуулж, ажилдаа орж байсан бол 2018 онд Ардын цахим түрийвчийг нэвтрүүлж, банкны төлбөр тооцоо хийж эхлэн, 2019 оны 1 сард бид Ард Аппын 2 дугаар хувилбарыг та бүхэндээ танилцуулсан. Ард Апп нь уламжлалт банкны үйлчилгээ болох хадгаламж, зээл, төлбөр тооцоо хийхээс гадна хөрөнгийн биржийн арилжаанд оролцох, гадаад валют авах, зарах, даатгалын үйлчилгээнд хамрагдах, крипто-валютаар гүйлгээ хийх, хувийн тэтгэврийн хуримтлалаа удирдах зэрэг боломжийг олгоод зогсохгүй та гэрээсээ гаралгүй дэлгүүрээсээ бараагаа захиалан авчруулах боломжийг олгох юм. Монголд анх удаа та банкны салбар дээр очилгүй хиймэл оюуны

тусламжтайгаар дансаа нээх, зээлээ авах болж байгаагаараа Ард Апп давуу талтай. Ард Кредит Монгол Шуудантай хамтран гадаад гуйвуулга, барьцаагүй зээлийн үйлчилгээг нэвтрүүлэхээр бэлтгэл ажлаа базаан туршиж эхэлсэн бол Ард Шопын хүргэлтийг Монгол Шуудан дангаараа хариуцан ажиллаж эхэллээ. Бид туршилтын байдлаар хамтарсан салбараа байгуулсан бол төрийн үйлчилгээг хөдөөд хүргэх ажлыг Монгол Шуудан холбогдох байгууллагуудтай хамтран эхлүүлээд байна. Монгол Шуудан бол Монголдоо төдийгүй дэлхийд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа ямар түвшинд явж болохын тод жишээ болж чадсан. Ард Секюритизын үйл ажиллагаа тогтворжиж, хөрөнгийн зах зээлийн хамгийн идэвхтэй оролцогч болоод зогсохгүй хамгийн олноор шинээр харилцагч татаж ажиллаж эхэллээ. Бид та бүхэндээ цахимаар хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох боломжийг нээж өгч чадлаа. Хөрөнгө оруулалтын судалгаан дээр тулгуурласан таны хамгийн найдвартай зөвлөх болон хамгийн чанартай IPO, бонд гаргадаг компани болох болзлыг бид хангаж чадлаа гэж үзэж байгаа. Ард Активын хөрөнгө нугаран өсч, Ард Лайф

үйл ажиллагаагаа тэлсээр байна. Ард Менежмент хувьчлалын сан босгох ажлаа үргэлжлүүлэн КриптоҮндэстэн болон манай үл хөдлөх хөрөнгийн сангуудыг удирдаж ирлээ.

АрдБитын хувьд 2019 оноос эхлэн үйл ажиллагаагаа идэвхжүүлж, Ард Санхүүгийн Нэгдлийн анхны лоялти хөтөлбөрийг гардан удирдахаар болж байгаа. 2019 оны 1 сард таны гар дээрх АрдКойн эргэлтэнд орох болно. Та анх манайд хөрөнгө оруулахдаа дэлгүүртэй болно гэж санаагүй байх. Тэгвэл бид танд хил хязгааргүй дэлгүүр болох АрдШопыг танилцуулахад таатай байна. Одооноос эхлээд таны авах гэж байгаа бараа чинь энэ дэлхийн хаана ч байж болно. Та түүнийг АрдШопоос захиалахад бид таны байгаа газар чинь хүргэж өгөх болно.

Хүчтэй, Хамтдаа гэж бид зүгээр л хэлж ярьдаг зүйл огт бишээ: Ард Санхүүгийн Нэгдэл Грэйп Сити, АйСиТи Групп, Мост Мони ПСП, Трассчэйн гэх зэрэг компаниудтай хамтран ажиллаж ирсэн бол ГоуПэй крипто түрийвч, Дижитал Эксченж Монголия, ЭМИСи Партнерс компаниудад стратегийн хөрөнгө оруулалтуудыг та бүхний өмнөөс хийлээ. Бид 2018 ондоо багтан Ард Риалти,

Ард Пропертиз, Ард Лизинг гэх шинэ компаниудыг үүсгэн байгуулж, Ардын ам бүлд нэмлээ. Таны хөрөнгөө оруулсан компанийн хувьд 2018 он бүхэлдээ амжилттай өрнөж, өндөрлөлөө. Бидний тооцоолж байгаагаар зөвхөн Ард Кредит, Ард Даатгал, Монгол Шуудангийн нөлөөллөөр манай нэг хувьцааны дотоод үнэлгээ 2019 онд 4 мянган төгрөгийг давах төлөвтэй байгаа болно. Харин миний дээр дурдсан бусад компани,

санаачлага, төслийн үр дүн, тэдгээрийн амжилт үүн дээр нэмэгдэж тооцогдохыг болгооно биз ээ? Таны мөнгө таны төлөө зогсолтгүй ажилласаар байгааг та харж байгаа байх.

Таны хөрөнгө оруулалтын мэлмий ямагт саруул байх болтугай! Шинээр гарч буй 2019 он Монголчуудын хувьд олз омог ихийг ивээх болтугай!

Хүндэтгэсэн,
Хутагт овогт Чулууны Ганхуяг

2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН



2018 онд Монгол Улсын эдийн засаг 6.9%-иар өсч, өмнөх оноос 1.8 хувиар өссөн байна. Энэ үзүүлэлт нь сүүлийн 4 жилийн хугацаанд хамгийн өндөр хувиар өссөн үзүүлэлт юм. Бүтээгдэхүүний цэвэр татвар 20.1%-иар, Боловсруулах үйлдвэрлэл 15.7%-иар, Санхүү болон даатгалын үйл ажиллагаа 12.3%-иар тус тус өссөн. Мөн үргэлжилсэн уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, өрхийн зээлийн олголт нэмэгдсэн зэрэг нь эдийн засгийн өсөлтөд ихээхэн нөлөөлсөн. Харин ипотекийн зээлийн олголт буурсантай холбогдуулан барилга болон бусад үйлчилгээний ажиллагаа 5 хүртэл

хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн улсын нэгдсэн төсвийн тэнцэл сүүлийн 8 жилийн хугацаанд анх удаа ашигтай гарсан байна.

Монгол төгрөгийн гадаад валюттай харилцах ханш МонголБанкны нэрлэсэн ханш дунджаар 1 ам доллар 2,633.37 төгрөг, 1 евро 2,988.53 төгрөгөөр тус тус тогтоогдсон байна. 2018 оны 2-р улиралд Монгол банкнаас урьдчилсан гүйцэтгэлээр мөнгөний нийлүүлэлт 15.9 их наяд төгрөг хийгдэж, өмнөх оны мөн үеэс 22.8 хувиар өссөн. Нийт хадгаламжийн хэмжээ 13.2 төгрөг

байгаагаас 77 хувийг төгрөгийн хадгаламж эзэлж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оноос 26.5 хувиар өссөнөөр 17.2 их наяд төгрөг болсон. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

2018 үнэт цаасны зах зээлийн хувьд өндөр өсөлттэй байж, олон дээд амжилтуудыг шинэчлэн тогтоож үнэт цаасны арилжаагаар 360.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 667.3 сая ширхэг үнэт цаас арилжсан байна. Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2.5 их наяд болж,

ТОП-20 дундаж индекс 20,076.5 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 2,032 нэгжээр буурсан байна.

Гадаад худалдааны тэнцэл 2018 онд 27.5 сая америк долларын ашигтай гарчээ. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 0.6 хувиар өсч, өмнөх оны жилийн эцсээс 8.1 хувиар өссөн байна. Орон сууцны үнийн индекс өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2018 онд Монгол улсын хувьд макроэдийн засгийн орчин тогтворжин, зээлжих зэрэглэл дээшилж, банкны зээлийн хүү 17.6 хувьд хүрч бууран, ажилгүйдлийн түвшин сүүлийн 3 жилийн хугацаанд хамгийн бага түвшинд хүрсэн зэрэг сайн үзүүлэлттэй жил болж өнгөрөв.

КОМПАНИЙН ТУХАЙ



Хөрөнгө Оруулагч Үндэстэн буюу Жинст Увс ХК

Хөрөнгө Оруулагч Үндэстэн буюу Жинст Увс хувьцаат компани нь 2016 оны 1 сарын 9-ний өдөр ирээдүйдээ хөрөнгө оруулж, Монгол орныхоо баялгийн эзэн болохоор сэтгэл шулуудсан 560 иргэн, аж ахуйн нэгжийн үүсэл санаачлагаар байгуулагдсан билээ. Ингэснээр Монголд анх удаа "crowdfunding" аргыг ашиглан олон нийтийн оролцоотой арилжааны банк байгуулах зорилгоор үүсгэн байгуулагдсан мэргэжлийн санхүү, хөрөнгө оруулалтын компани бий болсон юм. Анхны хувьцаа эзэмшигчдийн

хурлаараа бид Чингис хааны аравтын системийг ашиглан ТУЗ-өө нийт хувьцаа эзэмшигчдийнхээ дундаас нээлттэйгээр сонгон шалгаруулж томилсон юм. Тус хурлаар компанийн урт хугацааны зорилт дэвшилтэт технологи дээр үндэслэн Монголын анхны ард түмний банкийг үүсгэн бий болгох гэж тодорхойлсон.

Өнгөрсөн хугацаанд Хөрөнгө Оруулагч Үндэстэн нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Монгол Шуудан ХК, Ард Даатгал ХХК-д хөрөнгө оруулж байсан. 2016 оны 8 сарын

хурлаас Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийг Жинст Увс ХК-тай нэгтгэх, улмаар Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болгох түүхэн шийдвэрийг хуралд оролцогсдын 96.81 хувийн саналаар гаргасан. Улмаар тус шийдвэрийн үр дүнд Хөрөнгө Оруулагч Үндэстний 1,000 төгрөгний нэрлэсэн үнэтэй нэгж хувьцааны ханш Монголын Хөрөнгийн Бирж дээр 2017 оны жилийн эцсийн байдлаар нэгж 1,858 төгрөг, 2018 оны 12 сарын 31-ний байдлаар 2,341 төгрөг болсон нь компанийн үнэ цэнийг анх гарсан үнэлгээнээс 134 гаруй хувиар нэмэгдүүлснийг харуулж байна.

Манай компанийн дараагийн том зорилтот ажил бол Ард Санхүүгийн Нэгдэл ХК-г өөртөө нэгтгэж санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэгч тэргүүний байгууллага болох юм. Тус зорилтын хүрээнд бид 2018 оны 4 сарын 28-ны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг Жинст-Увс ХК-тай нэгтгэх шийдвэрийг гаргаж хоёр талаас холбогдох ажил гүйлгээ хийгдэн нэгдэх үйл явц сүүлийн шатандаа явж байна. Хоёр компани нэгдсэнээр компанийн хувьд орчин үеийн дэвшилтэд технологи дээр суурилсан "Финтек" банк болох зорилгодоо нэг том алхмаар дөхөж очих юм.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчид	2018 оны IV улирал	
	Хувьцааны тоо	Эзлэх хувь
Ард Секюритиз	156,137	9.37%
Ард Даатгал	118,662	7.12%
Ард Кредит	83,897	5.04%
Энхтулга Анар	50,000	3.0%
Mongolian Swan Corporation	36,700	2.20%
Чулуун Ганхуяг	31,528	1.89%
Tai Tam Corporation	30,000	1.80%
Хадбаатар Нямбадраа	23,377	1.40%
Ард Лайф	22,886	1.37%
Гомбожав Эрдэнээ	20,000	1.20%
Бусад	1,092,751	65.59%
НИЙТ ДҮН	1,665,938	100.00%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Ч.Ганхуяг
ТУЗ-ийн дарга



П.Батбаяр
ТУЗ-ийн дарга



А.Батболд
ҮАЭ захирал



Г.Цогбадрах
Гүйцэтгэх захирал



С.Халиунаа
ХДХХ захирал



М.Сэргэлэн
Ерөнхийлөгч



А.Азбаяр
Гүйцэтгэх захирал



Б.Солонго
Гүйцэтгэх захирал



Б.Гантулга
Гүйцэтгэх захирал

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



Ж.Алтангүний
Гүйцэтгэх захирал



Г.Энхсаруул
Нягтлан бодогч

2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- ▲ Жинст Увс ХК болон Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК нэгдэж, бүртгэлийн ажиллагааг амжилттай хийж дуусгалаа.
- ▲ Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийг татан буулгав;
- ▲ Жинст-Увс (Хөрөнгө Оруулагч Үндэстэн) ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар түүхэн шийдвэр гаргаж Ард Санхүүгийн Нэгдэлтэй нэгдэхийг батлав;
- ▲ Монголын Хөрөнгийн бирж дээр III ангиллаас II ангилал руу шилжив.



2018 оны I дүгээр улиралд Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийг татан буулгах ажиллагааг амжилттай хийж дуусгасан. Жинст Увс ХК-ийн хаягийн бүртгэлийн өөрчлөлтийг Увс аймгаас шилжүүлэн авчирсан.

2018 оны 4 сарын 28-ны өдөр Жинст Увс

ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулсан. Тус хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгон, баталсан. Мөн Ард Санхүүгийн Нэгдэл ХК-тай нэгдэх гэрээний төслийг баталснаар хоёр компани нэгдэх түүхэн шийдвэр гарч, нэгдэх үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд шаардлагатай мэдээлэл, баримт



бичиг болох аудитын дүгнэлт, хууль зүйн дүгнэлт, үнэлгээний компанийн дүгнэлт зэрэг баримт бичгийг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж зэрэг байгууллагуудад хүргүүлсэн. 2018 оны 12 сарын 29-ний өдөр Монголын Хөрөнгийн Биржээс нэгдэх тухай зөвшөөрөл олгосон. Одоо Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрлийг хүлээж байна.

Уг шийдвэртэй холбогдуулан 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдоролцоогүй эсвэл хурлаас гарсан шийдвэртэй эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүссэн болно. Үүний дагуу мэдээллийг олон нийтэд холбогдох журмын дагуу хүргүүлж ажилласан. Шаардах эрхээ

хэрэгжүүлэхээр нэг ч хувьцаа эзэмшигч хүсэлт гаргаагүй болно.

2018 оны 8 сард Монголын Хөрөнгийн Биржийн бүртгэлтэй компаниудын ангиллыг дахин үзэж Жинст Увс ХК-ийг III ангиллаас II ангилал руу шилжүүлсэн.

2018 оны туршид тогтмол хувьцаа эзэмшигчиддээ олон нийтийн сүлжээ буюу Фейсбүүк болон Твиттер ашиглан үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг тухай бүр давхар хүргүүлж ажиллав. Зохицуулагч байгууллагуудад цаг хугацаанд бүхий л мэдээллийг хүргүүлж мөн ажилласан байна.

Компанийн нийт хөрөнгө нь 2.7 тэрбумаас 3.1 тэрбум болж нэмэгдлээ. Тайлант хугацааны цэвэр ашиг нь 173 сая төгрөг байна. 2018 оны 12 сарын 31-ний өдөр Монголын Хөрөнгийн Биржийн хаалтын ханш нь 2,341 төгрөгт хүрэв.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ



891,563 ширхэг




5.19%

Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа

Дундаж өртөг	1,622
Тоо	891,563
Нийт өртөг	1,446,115,186
Өнөөгийн ханш	3,300
Хэрэгжүүлж болох ашиг	1,228,573,814

ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

2018 оны хувьцааны үнэ (MSE:JIV)




**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН**

Зах зээлийн мэдээлэл


Хаалтын ханш	2,341
Зах зээлийн үнэлгээ	3,9 тэрбум
52 долоо хоног	576.15 - 2,341

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ

Санхүү



Крипто



Дэд бүтэц



2018 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ЖИНСТ УВС” ХК -ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санал дүгнэлт

Бид 2018 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Жинст Увс” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Жинст Увс” ХК -ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын

дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо

нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Аудитаар доорх асуудлыг аудитын гол асуудал болгон толилуулж байна.

Тайлангийн хугацаанд компанид Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн зохион байгуулах ажлыг эхлүүлсэн. Өөрчлөн зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааг хэлэлцүүлэхээр компанийн ТУЗ-өөс 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулж хэлэлцүүлж Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг нэгтгэх, цаашид Ард Санхүүгийн Нэгдэл ХК гэсэн оноосон нэрийг ашиглахаар шийдвэрлэсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн Ард Санхүүгийн

Нэгдэл ХК-тай "ЖИНСТ УВС ХК-д АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ийг нэгтгэх гэрээ" байгуулж гэрээнд талуудыг нэгтгэх үйл ажиллагааны журам боловсруулан хавсралтаар оруулсан ба нэгтгэлийн зорилго, компанийн хувьцааны нэгжийн үнийг шилжүүлэн тооцох, хөрөнгийн үнэлгээ зэрэг нэгтгэлтэй холбоотой зүйлсийг харилцан тохиролцсон.

Компанийн тухай хуулийн дагуу нэгтгэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр эрх бүхий байгууллагуудад материалаа бүрдүүлэн өгсөн бөгөөд Монголын Хөрөнгийн Биржийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/144 дугаар тушаалаар Жинст Увс ХК-ийн хувьцаанд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааг нэгтгэн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 28,614,263 ширхэг болгон өөрчлөх, Жинст Увс ХК-ийн оноосон нэрийг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болгон өөрчлөхийг зөвшөөрч Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК болон Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлсэн.

Аудитаар компаниудын засаглах удирдлагын тогтоол, шийдвэр,

компаниудын хооронд байгуулсан гэрээ, нэгтгэх үйл ажиллагааны журам, Монголын Хөрөнгийн Биржийн Гүйцэтгэх захирлын тушаал зэрэг эрхзүйн баримт материалуудтай танилцсан. Нэгтгэх үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрсний үндсэн дээр олон нийтэд хүргэх, холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулахаар хүлээгдэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа

үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй

байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн

шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.

Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон

тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.

Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.



Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн ба бид тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**2019 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 01-НИЙ ӨДӨР**

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	<u>Тодруулга</u>	2018.12.31 <u>мянган төгрөг</u>	2017.12.31 <u>мянган төгрөг</u>
ХӨРӨНГӨ			
<u>Эргэлтийн хөрөнгө</u>			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6.1.	178.8	791.3
Дансны авлага	6.2.	396,194.4	46,249.6
Татвар, шимтгэлийн авлага	6.5.	3,939.7	3,939.5
Бусад санхүүгийн хөрөнгө	6.3.	30,000.0	30,000.0
Урьдчилж төлсөн зардал	6.6.	203.0	203.0
Эргэлтийн хөрөнгийн дүн		<u>430,515.9</u>	<u>81,183.4</u>
<u>Эргэлтийн бус хөрөнгө</u>			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	6.7.	403.0	801.8
Биет бус хөрөнгө (цэвэр)	6.8.	807.9	906.6
Урт хугацаат хөрөнгө оруулалт	6.3.	2,670,644.3	2,629,125.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		<u>2,671,855.2</u>	<u>2,630,833.4</u>
НИЙТ ХӨРӨНГӨ		<u>3,102,371.1</u>	<u>2,712,016.8</u>

	<u>Тодруулга</u>	2018.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
ӨР ТӨЛБӨР			
<u>Богино хугацаат өр төлбөр</u>			
Дансны өглөг	6.4.	<u>6,607.3</u>	<u>112,731.6</u>
Цалингийн өглөг	6.4.	<u>109.7</u>	<u>791.2</u>
Бусад өглөг			
Банкны богино хугацаат зээл			
Зээлийн хүүгийн өглөг			
Татварын өглөг	6.5.	20,112.8	54.2
ЭМ НДШ-ийн өглөг			
Урьдчилж орсон орлого			
Богино хугацаат өр төлбөрийн дүн		<u>26,829.8</u>	<u>113,577.0</u>
<u>Урт хугацаат өр төлбөр</u>			
Урт хугацаат зээл			
Хойшлогдсон татварын өглөг	6.9.	122,646.2	102,560.9
Урт хугацаат өр төлбөрийн дүн		<u>122,646.2</u>	<u>102,560.9</u>
Өр төлбөрийн дүн		<u>149,476.1</u>	<u>216,137.9</u>
<u>Өөрийн хөрөнгө</u>			
Энгийн хувьцаа	6.10.	1,665,938.0	1,665,938.0
Нэмж төлөгдсөн капитал	6.10.	41,897.3	41,897.3
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц сан	6.10.	1,103,816.5	923,048.4
Хуримтлагдсан үр дүн	6.10.	141,243.2	(135,004.8)
Өөрийн хөрөнгийн дүн		<u>2,952,895.0</u>	<u>2,495,878.8</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		<u>3,102,371.1</u>	<u>2,712,016.8</u>

ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	<u>Тодруулга</u>	2018.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Борлуулалтын орлого			
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			
Нийт ашиг			
Түрээсийн орлого	6.11.	<u>4.2</u>	<u>322.2</u>
Хүүний орлого	6.11.		<u>3,289.2</u>
Ногдол ашгийн орлого	6.13.	100.9	<u>626.8</u>
Бусад орлого			
	6.12.	(3,327.9)	
Борлуулалт, маркетингийн зардал	6.12.	(23,230.1)	<u>(203,463.6)</u>
Ерөнхий удирдлагын зардал	6.11.	(1,389.9)	<u>(6,373.4)</u>
Санхүүгийн зардал	6.14.	(1,416.2)	<u>(8,454.4)</u>
Бусад зардал			
Гадаад валютын ханшийн зөрүү олз (гарз)	6.11.		<u>(169.4)</u>
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	6.11.	222,410.6	148,725.9
Татварын өмнөх ашиг (алдагдал)		<u>193,151.7</u>	<u>(65,496.7)</u>
Орлогын албан татварын зардал	6.15.	<u>(19,456.8)</u>	<u>(361.1)</u>
Тайлант жилийн татварын дараах ашиг (алдагдал)		<u>173,694.9</u>	<u>(65,857.8)</u>
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц		473,242.5	1,064,427.8
Бусад дэлгэрэнгүй орлогын хойшлогдсон татварын зардал			<u>(106,442.8)</u>
Тайлангийн хугацаанд борлуулж бодит болж хэрэгжсэн олз		(292,474.4)	<u>(34,936.7)</u>
Нийт дэлгэрэнгүй орлого		<u>180,768.1</u>	<u>923,048.4</u>

ӨМЧИЙН ӨӨРЧӨЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувьцаат капитал мянган төгрөг	Нэмж төлөгдсөн капитал мянган төгрөг	Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц мянган төгрөг	Хуримтлагдсан ашиг (алдагдал) мянган төгрөг	Нийт мянган төгрөг
2016 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	5,323.0			(8,703.0)	(3,380.0)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа					
Залруулагдсан үлдэгдэл	5,323.0			(8,703.0)	(3,380.0)
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)				(65,857.8)	(65,857.8)
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн	1,660,615.0	41,897.3	923,048.4	(60,444.0)	2,565,116.7
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц өсөлт, (бууралт)					
Хувьцаат капиталын өсөлт, бууралт					
2017 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,665,938.0	41,897.3	923,048.4	(135,004.8)	2,495,878.9
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа					
Залруулагдсан үлдэгдэл	1,665,938.0	41,897.3	(92,304.8)	102,553.2	10,248.4
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)			830,743.6	(32,451.6)	2,506,127.3
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн				173,694.9	173,694.9
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц өсөлт, (бууралт)			273,072.9		273,072.9
Хувьцаат капиталын өсөлт, бууралт					
2018 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,665,938.0	41,897.3	1,103,816.5	141,243.2	2,952,895.0

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2018.12.31 <u>мянган төгрөг</u>	2017.12.31 <u>мянган төгрөг</u>
1.Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	5,807.9	4,492.2
<u>1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</u>		4,492.2
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого		
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас,санхүүжилтийн орлого		
Бусад орлого		
<u>1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</u>	<u>(6,424.6)</u>	<u>(202,935.2)</u>
Ажиллагсдад төлсөн мөнгө	(1,652.0)	(49,339.8)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	(588.9)	(12,234.9)
Бараа материал худалдан авахад төлсөн		
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө		(6,170.0)
Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	(20.0)	
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	(188.6)	(6,685.8)
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		
Бусад мөнгөн зарлага	(3,975.1)	(128,504.7)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(616.7)	(198,443.0)

2018.12.31
мянган төгрөг

2017.12.31
мянган төгрөг

2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Хүлээн авсан хүүгийн орлого	4.2	87.2
Ногдол ашгийн орлого		2,339.8
Бусдад олгосон зээл, урьдчилгааны буцаан төлөлт		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		318,317.0
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		(120,784.7)
Бусдад олгосон зээл, урьдчилгаа		(151,274.0)
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ

4.2 **48,685.3**

2018.12.31
мянган төгрөг

2017.12.31
мянган төгрөг

3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Зээл авсан		159,098.6
Эргэн төлсөн зээл		(29,446.4)
Хувьцаа гаргалтын орлого		
Бусад санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого		

Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ

129,652.2

Валютын ханшийн цэвэр өөрчлөлт		(13.9)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(612.5)	(20,119.4)

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл **791.3** **20,910.6**

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл **178.8** **791.3**

Хүчтэй. Хамтдаа.



info@ardholdings.com



ardholdings.com



цэнэг.эрдэмтэй.өнгөлөх



7707 8080